

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН  
САНАМЖ БИЧГИЙН ХҮРЭЭНД 2020-2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2020 ОНЫ БИЕЛЭЛТ

2021 оны 01 дүгээр сарын 22

Багануур дүүрэг

№	Гүйцэтгэх ажлууд	Төлөвлөсөн хугацаа	Биелэлт	Дүгнэлт	Гүйцэтгэл
1.	Багануур үйлдвэрлэл, технологийн парктай танилцах, хамтран ажиллах хэлэлцүүлэг хийх	2020.01 сар	- МУИС-ийн дэд захирал Ч.Лодойравсал ахалсан 10 хүний бүрэлдэхүүнтэй салбар сургуулиудын удирдах багийг 2020.01.09-ны өдөр Багануурт хүлээн авч, паркийн үйл ажиллагаа болон судалгаа, шинжилгээ хийгдсэн ажлуудын талаар танилцуулга хийж, хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлан, Багануур ХК-ийн уурхайн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулсан.	2021 онд төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан үргэлжлүүлнэ.	100%
2.	БҮТП-ийн үйлдвэрүүдэд хэрэгжиж болохуйц шинэ технологи, патентлагдсан бүтээлийн судалгаа хийх	2021.01-09 сар	БҮТП-ийн үйлдвэрүүдэд хэрэгжиж болохуйц шинэ технологи, патентлагдсан бүтээлийн судалгааг төлөвлөсөн хугацаанд нэгтгэн авна.	Цаашид он бүрт патентлагдан гарах шинэ бүтээлийн жагсаалтуудыг нэгтгэн мэдээллийн санг баяжуулна.	-
3.	Багануурын уурхайн хаягдал түүхий эдэд суурилсан инновацийн бүтээгдэхүүн гаргах судалгаа хийх Үүнд: → Уурхайн хөрсний шорооны хаягдлаас барилгын материал, сэргээгдэх эрчим хүчний чиглэлийн түүхий эд гаргах судалгаа → Уурхайн нүүрс, шорооноос будаг гаргах судалгааны ажил	2 жилд	Олон улсын хамтын ажиллагааны КОЙКА байгууллагын төр хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөрт уурхайн нүүрснээс шороон будаг гаргах төслийг 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 22 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. - ШУТИС-ийн эрдэмтэд, судлаачдын эрдэм шинжилгээний ажил, шинэ бүтээл болон паркад нэвтрүүлж болохуйц судалгаа бүтээлийг цахим мэдээллийн хэрэгсэл ашиглан судалж байгууллагын мэдээллийн санд нэгтгэх ажлыг зохион байгуулсан.	Цаашид инновацийн төслүүдийг хамтран боловсруулах чиглэлээр зорин ажиллана.	100%
4.	БҮТП-ийн туршилт, судалгааны ажилд МУИС-ийн мэргэжлийн лабораториудыг ашиглах боломжоор хангах	2 жилд	- 2020 онд судалгааны ажлуудыг хөрөнгөгүйн улмаас гүйцэтгээгүй. - Мөн онд паркийн ЭШСИИТ-ийн засварын санхүүжилтийг улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр саналаа хүргүүлж ажилласан.	Цаашид МУИС-ийн химийн лабораториудыг түшиглэн судалгааны ажлуудыг гүйцэтгэнэ.	-

5.	БҮТП-ийн эрдэм шинжилгээний судалгаа, инкубатор, инновацийн төвийн үйл ажиллагаа, томоохон төслүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	Жилдээ	2020 онд засвар, тоног төхөөрөмжийн тооцоог шинэчлэн НШУУИГ, НЗДТГ-т тус тус хүргүүлсэн.	ПИИСТ-ийн барилгын засвар, тоноглох асуудлыг шийдвэрлүүлсний дараагаар төслийг хэрэгжүүлэхэд эрдэмтэд багш нарын зөвлөгөөг авна.	-
6.	МУИС-ийн судлаачдын бий болгосон оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулахад БҮТП-аас дэмжлэг үзүүлэх	2 жил	МУИС-ийн судлаачдын шинэ судалгаа, бүтээлийн ажлуудыг НШУУИГ, ҮТП-уудтай хамтран зохион байгуулсан уулзалтуудад танилцуулж ажиллаж байна.	Цаашид цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан паркийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой эрдэмтэн багш нарын бүтээлүүдийг сурталчилж ажиллана.	100%
7.	Хамтран боловсруулсан удирдамжийн дагуу БҮТП-д МУИС-ийн оюутнуудыг дадлага хийлгэх	Хичээлийн жилээр	Парк оюутнуудыг хүлээн авч, дадлага хийлгэх баазгүй байна.	Бааз бүрдүүлсэний дараа дадлага хийлгэнэ.	-
8.	Үйл ажиллагаа болон шинэ техник, технологийн мэдээлэл цахимаар ба бичгээр солилцож байх	Тогтмол	МУИС-тай хамтран “Шар сүүг дахин боловсруулж шим тэжээлийн болон эмчилгээний зориулалттай бүтээгдэхүүн гаргах” инновацийн үйлдвэрийн төслийн судалгааны ажлыг эхлүүлэх хамтарсан төлөвлөгөөг гаргасан.	Цаашид судалгааг эхлүүлэн үр дүнтэй болгох арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ.	100%
9.	Паркийн үйл ажиллагаатай хамаарах асуудлаар явагдах Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, үзэсгэлэнд МУИС болон паркийн төлөөллүүдийг тогтмол оролцуулж байх	Тогтмол	2020 онд Эрдэм шинжилгээний хурлыг цар тахалтай холбоотойгоор тус байгууллага зөвхөн харьяа сургуулиудын хүрээнд зохион байгуулсан.	Цаашид эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд оролцоно.	-
<b>Хэрэгжилтэд тооцох боломжгүй арга хэмжээний тоо</b>					<b>5</b>
<b>Хэрэгжилтийн дундаж хувь</b>					<b>100%</b>

ХЯНАСАН:  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЙТЭН

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
КЛАСТЕР ИНЖЕНЕР



Ч. ЭЛБЭГСАЙХАН

Б.МӨНГӨНХУЯГ

Э. ЭНХЗАЯА